

ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛЫН БУДДЫН ФИЛОСОФИ СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖИЛТ

М.Гантуяа - МУИС-ийн Шашин судлалын тэнхмийн эрхлэгч, доктор, дэд профессор

Буддизм бол Дорно дахины ард түмний үзэл санааны нэгдмэл байдлыг илэрхийлж ирсэн, өнөө үед Өрнийн ертөнцөд ч өргөн нэвтэрч байгаа баялаг утга агуулга бүхий оюуны соёлын томоохон үзэгдэл мөн билээ. Буддизм хэмээх энэхүү соёл нь хүн төрөлхтний үүсгэн хөгжүүлж ирсэн мэдлэг ухаан, урлаг соёлын олон салбарыг өөртөө багтаадаг боловч бүгдийг нэгэн үзэл санаан дор нэгтгэж чаддагаараа өөрийн гэсэн өвөрмөц аргазүйг боловсруулсан байдаг. Тухайлбал, Буддизмын хүрээнд философи, логик, хэл шинжлэл, анагаах ухаан, одон зурхайн ухаан, урлагийн бүх салбар, мэдлэг ухаан багтана. Эдгээр олон салбар ухааныг Буддизм хэмээх нэгэн нэрийн дор шингээх эх булаг нь Буддын философи мөн.

Монголчууд эрт дээр цагаас Буддын ухааныг шүтэн дээдэлж ирсний гол учир нь чухам түүний гүн ухааны үндсийг ухаарч судалдаг байсанд оршино. Монголчууд Буддын гүн ухаанд суралцахдаа эртний Энэтхэгээс уламжилж ирсэн аргыг нарийн мөрдөж, гэхдээ монголчуудын өөрийн гэсэн билиг ухааны цар хүрээнд тохируулан нягтлан шинжилж иржээ. Монголын ШУА-ийн Философийн хүрээлэнгийн захирал Г.Чулуунбаатар: “Буддизм шашин бол монгол иргэншлийн хэвшмэл дүр төрхийг илүүтэй илэрхийлж, монгол хүн монголоороо байж орчин цагийн бусад хөгжингүй иргэншлийн дэвшилт ололтыг хүлээн авах үндэсний суурь дэвсгэрийн язгуур шинжийг өвлөн уламжлуулах нөлөөтэй” гэсэн буй. Монголын Буддын шашны төв хийд болох Гандантэгчинлэн хийдийн тэргүүн Д.Чойжамц хамба: “Буддын шашин нь бөөгийн мөргөлийн болхи бүдүүлэг зан үйлийг халж өөрчлөхийн хамт Монголын нутагт Энэтхэг, Төвдийн соёлын ололтуудыг авчран дэлгэрүүлж соён гэгээрүүлэх үүрэг гүйцэтгэжээ” хэмээн өгүүлсэн буй.

Монгол сэтгэгч мэргэдээс буддын философийн асуудлаар хэдэн арван мянгаар тоологдохуйц арвин их бүтээл туурвисан нь эртний Энэтхэг, Төвдийн соёлын өв их сангаас хойч үедээ уламжлан үлдээсэн төдийгүй түүнийг монгол ахуйд гохируулан цааш гүнзгийрүүлэн хөгжүүлсэн болно.

Монголчуудын туурвисан буддын философийн ном зохиолын тухайд гэвэл эртний энэтхэгийн хийгээд хожуу үеийн тэвдийн буддын сонгодог ном зохиолуудыг судлан тайлбар, хураангуйлал хийгээд зогсоогүй, ахуй, танин мэдэхүйн тодорхой асуудал, логик, сэтгэл зүй, философийн түүхийн чиглэлээр философийн бие даасан бүтээл олныг туурвисан нь тухайн салбартай ихэд алдаршиж зава (үндэс) болсон нь буй бөлгөө.

Доктор Ч.Жүгдэр агсан монголын буддын сэтгэгчдийн бүтээлүүдийг тайлбартны ба шинэтгэгчдийн гэсэн хоёр үндсэн бүлэгт хувааж үзэх арга зүйг боловсруулсан билээ. Монголын буддын сэтгэгчид буддын утга зохиолд тайлбар хийхийн өмнө тэдгээрийг орчуулах нэн чухал ажлыг гүйцэтгэж байжээ. Иймээс монголчуудын туурвисан буддын утга зохиолыг орчуулга, тайлбар, бие даасан зохиол гэсэн гурван хэсэгт авч үзэх арга зүйн асуудлыг дэвшүүлсэн буй.

Монголчуудын буддын ном зохиолоос орчуулж тайлбарлах ажил бүр XIY зуунаас эхэлсэн байна. Үүнд, XIY зууны монголын сэтгэгч Чойжи-Одсэрийн бичсэн “Бодьчарьяаватарагийн тайлбар”, “Банзрагчийн төгсгөлийн үг”, “Махагалын магтаал” зэрэг зохиол, “Бодьчарьяаватара” зохиолын орчуулга, Шаравсэнгийн орчуулсан “Субашид”, “Долоон өвгөний судрын” орчуулга зэрэг нь эзэнт улсын үед монголын сэтгэгчид буддизмын аль чиглэл урсгал, онол сургаалыг илүү сонирхон судалж байсныг тогтоох чухал хэрэглэгдэхүүн болж байгаа юм. Монголчууд XII зуунаас энэтхэг, төвдийн сэтгэгчдийн зохиол бүтээлийг монгол хэлнээ орчуулан барлах үлэмж их ажлыг хийсэн болно. Тухайлахад л, “Ганжуур”, “Данжуур” хэмээх их хөлгөн судруудыг монгол хэлнээ бүрэн орчуулж барласан нь монголчууд буддын сургаалыг бүхэлд нь дэлгэрэнгүй судалж байсныг нотлон харуулж буй тодорхой баримт даруй мөн болно.

Монгол Данжуурын Абхидхармын аймагт эртний энэтхэгийн нэрт сэтгэгч Васубандугийн (IY зуун) “Авхидхармакошакарика” хэмээх алдарт зохиол болон түүнд Санхабадра, Пурнававархта, Яшомитра зэрэг сэтгэгчдийн хийсэн тайлбарууд, нийт 10 гаруй боть зохиол буй.

Буддын философийн мадхьямака сургуультны 20 шахам зузаан боть, нийт 150 гаруй ном зохиол монгол Данжуурт хадгалагдаж байгаа юм. Эдгээрийн дотор тус философийг үндэслэгч Нагаржуна (II зуун), түүний томоохон төлөөлөгч Арьядева (II зуун), Чандракирти (YII зуун) нар, өөрийн үндэстийн болон хэтрүүлэгч төв үзлийг үндэслэгч Буддхапалита, Бхававивека (Y зуун), буддын мадхьямака-йогачара философийн эх үндсийг тавигч Шантаракшита, Камалашила (IX зуун) зэрэг томоохон сэтгэгчийн бүтээлийг онцлон дурдваас зохино.

Данжуурын сэтгэлийн төдийтний аймагт буддын йогачара философийг үндэслэгч Асанга (IY зуун), Васубанду нарын туурвисан бөгөөд “Майдар лугаа барилдсан хорин ном” хэмээн алдаршсан тус чиглэлийн 20 гол зохиол хийгээд Жинамитра, Гунапрабха, Стирамати, Винитадева зэрэг йогачара философийн томоохон төлөөлөгчийн зохиолууд хадгалагдаж байгаа юм. Ерөөс Данжуур бичигт йогачара сэтгэгчдээс янз бүрийн үед туурвисан 30 шахам зузаан боть, нийт 140 гаруй зохиол буй болно.

Мөн Дигнагийн (Y зуун) “Прамана-самуччая” (монг. Шалгадаг хотлоос түүсэн) тэргүүтэй буддын логикийн 20 боть зохиол байгааг тэмдэглэе.

“Энэтхэг, Төвдийн соёлын их өв болсон Ганжуурын 108 боть, Данжуурын 225 боть, нийтдээ 5000 гаруй номыг багтаасан олон боть судрыг өөрийн хэл дээр орчуулан хэвлэж чадсан явдал... нүүдэлчин монголчуудаас гадаад, дотоодын бэрх давхар дарлагдлын үед бүтээж чадсан гайхаж биширмээр соёлын өв тэгш амжилт мөн болно” Монголын нэрт эрдэмтэн, академич Ц.Дамдинсүрэн дүгнэсэн юм.

... Түүний сацуу монголын сэтгэгчдээс буддын философийн салбарт хийсэн ажил нь дан ганц орчуулгаар хязгаарлагдаж байгаагүй юм гэдгийг тэмдэглэх нь чухал. Буддын философийн чиглэл, сургуультнуудын талаар ном зохиол туурвиж, эртний энэтхэг, төвдийн олон тооны ном, сударт тайлбар, зүүлт, хураангуйлал хийж, мөн сурах бичиг зохиож бичсэн, бас ч буддын философи, логикийг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал хувь нэмрийг оруулсан

сэтгэгч олноороо төрсөн. Гандантэгчинлэн хийдийн гавж С.Гомбожав буддизмын янз бүрийн асуудлаар ном зохиол бичсэн доод зах нь 200 гаруй монгол сэтгэгчийн бүтээлийг тоолон гаргасан. Эдгээрийн дотор буддын төв үзлийн асуудлаар ном зохиол туурвисан сэтгэгч 30 гаруй, билиг барамид болон шалгадаг ухаанаар ном зохиосон 20 гаруй сэтгэгч байгаа юм. Тухайлбал, сүмбэ хамба Ишбалжир (1704-1788), сахар гэвш Лувсанчүлтэм (1740-1810), хамба номун хан Агваанхайдав (1779-1838), цорж гавж Агваанбалдан (1797-1864), гавж Данзанчойнзод (XIX), оргиочийн лам гавж Лувсанбалдан (XIX), Дандар аграмба (1835-1915), зава Дамдин (1864-1937), Цэмбэл гүүш (XIX-XX зууны эх) зэрэг мэргэдийн бичсэн буддын философийн ном зохиол үлэмж олон буй юм.

Монгол сэтгэгчдийн бичсэн тайлбар зохиолуудын нийтлэг нэгэн шинж нь тэд үндсэндээ төвд хэлээр бичигдсэн явдал мөн. Ерөөс ХҮИІ зууны орчмоос эхлэн төвд хэл Монголын сэтгэгчдийн дунд өргөн дэлгэрч, улмаар нийт монголчуудын шашин мөргөлийн төдийгүй, мөн зарим талаар аливаа эрдэм мэдлэгийн хэлний үүргийг гүйцэтгэх болсон байна. Дундад зууны Европ дахинд латин хэл, Ойрхи болоод Дундад Дорно дахинд араб хэлний гүйцэтгэж байсан шиг мөн тиймэрхүү үүргийг Монгол орны хувьд төвд хэл гүйцэтгэсэн болно. Монголын буддын философи сэтгэлгээний түүхэнд холбогдох эх сурвалж хэрэглэгдэхүүн үнэнхээр арвин бүрдмэл байгаа боловч эдгээр эх сурвалжийг судалгаа шинжилгээний хүрээнд аль болохуйц өргөнөөр татан оруулах явдал чухал байгаа юм.

Монголын буддизмд философи буюу дотоод ухааныг авч үзэхдээ Чойрын таван боть хэмээх таван бүрэлдэхүүн хэсгээр номлодог уламжлал тогтжээ. Үүнд, Авидарма, Билиг барамид, Төв үзэл, Учир шалтгааны ухаан, Винайн аймаг болой. Чойрын таван ботиор л гэхэд Авидармын аймаг Данжуурын 8 ботийг, Билиг барамидын аймаг Ганжуурын 20, Данжуурын 16 ботийг, Мадхьямака аймаг Данжуурын 16 ботийг тус тус эзэлж байгаагаас үзэхэд буддын философийн монгол хэлт эх бичиг арвин баялаг бөгөөд судалгаа шинжилгээ хүлээн хадгалагдсаар байна.

1990-ээд оноос хойш Монголд буддын философи судлал урьд өмнө байгаагүй ихээр өргөжин тэлсэн билээ. Тухайлбал, Учир шалтгааны ухааны чиглэлээр судлаач, доктор Т.Содномдарга агсан төвд Данжуур дахь буддын логикийн 20-иод сэтгэгчдийн 60 гаруй эх сурвалж, ялангуяа Дигнагийн "Есөн гаргалгааны хүрдэн" зохиолд Агваандандарын тайлбараар дамжуулан анализ хийж буддын логик гаргалгааны бүхий л төрөл зүйлийн агуулга нь хэлбэр ба сэтгэл зүйн зохист харилцаан дээр тулгуурласан, хэрэглээний талыг илүүтэй тавьсан, "зүгийн юм", "даган түгэхүй", "эргэн түгэхүй" гэсэн гурвал зарчмаар зөв сэтгэх арга зүйн үндэс болдог онцлогтой хэмээн тогтоожээ. Энэхүү буддын логикийн судлагаанд залуу судлаач Э.Ариунаа "Монголын буддын логикчдын намтар бүтээлээс" хэмээх магистрын ажлаа нэгтгэсэн.

Дэд доктор Г.Лхагвасүрэн агсан буддын тогтсон тааллын ёс Монголд хэрхэн дэлгэрч хөгжсөн түүхийг тоймлосон ба Ишбалжир, Ролбийдорж, Дамцагдорж, Агваанбалдан, зава Дамдин, Агваанцэрэн зэрэг монголын зарим нэрт сэтгэгчдийн зохиол бүтээлд тогтсон тааллын ёсны арга зүйг хэрхэн хэрэглэсэн байдлыг гарган харуулжээ.

Академич Г.Лувсанцэрэн багш агсан Буддын Төв үзлийн философийн үндсэн зарчмууд, түүний гол агуулга болсон хоосон чанарын үзлийн философи утгыг тайлан гаргаж, эх орны Буддын судлалд онол-аргазүйн үүднээс өөрийн өвөрмөц үнэлэлт дүгнэлтийг өгсөн эрдэмтэн билээ. Тэрээр дэлхийн олон орны буддын судлаач эрдэмтдийн янз бүрийн үзэл тайлбарлалыг харьцуулан шинжилж үзээд, хоосон чанар нь бүхний язгуурт байх аливаа тодорхой шинж үгүй чанар, үнэмлэхүй хийгээд янагуухийн нэгдэл болсон дотоод шилжимтгий харилцаа юм гэж тодорхойлоод, иймээс юмсын уг чанарт эцсийн хуваарьгүй эгэл хэсэг, эцсийн үл хуваагдах агшин гэж байхгүй, тэнд ямар ч баригдах биет юмыг тавьж болохгүй, чухам л хоосон, тэгэхдээ оргүй хоосон бус, харилцаа л байна, иймээс ч Буддын төв үзлийн гүн ухааны оргилд гарч, донид доглосон Монгол мэргэд юмсын нэвчингүй чанарыг барьсан байдаг хэмээн дүгнэсэн билээ.

Миний бие дээрхи багш нарынхаа судалгааны аргазүйд суралцаж, "Билиг барамидын сургаалын философийн үзэл" сэдвээр дэд докторын зэрэг хамгаалсан бөгөөд энд буддын танин мэдэхүй, сэтгэл зүй, ёс суртахууны сургаалын амьд нэгдэл, Сансар ба Нирвааныг тэгш чанар буюу хоосон чанарт барьдаг Их хөлгөний сургаалын үндсийг гаргахыг зорьсон. Билиг барамидын эх сурвалжийн тоймыг судлах ажлаа үргэлжлүүлэн билиг барамидын монгол тайлбаруудын утга санааг нэгтгэн дүгнэхээр ажиллаж байна. Мөн Бага хөлгөний философийн үндэс болох Абхидхарма сургаалын хүрээнд дэвшүүлсэн гол асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийн үзэл санааны ерөнхий онцлогийг гаргасан өгүүллүүд, ном зохиолыг нийтлүүлсээр ирлээ. Эдгээр судалгаагаараа Бага ба Их хөлгөний онолын уялдаа холбоог тогтоох зорилго тавьж байна.

Монголын буддын сэтгэгчдийн бие даасан бүтээл туурвил, үзэл санааны талаархи судалгаанд доктор Д.Дагвадорж агсаны "Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг", судлаач Г.Лхагвасүрэн агсаны Данзанравжаагийн гүн ухааны судалгаа, Т.Содномдаргиа агсаны Агваандандарын логикийн судалгаа, Л.Тэрбиш докторын Дамцагдоржийн ертөнцийн үүсэл хөгжлийн тухай судалгаа, дэд доктор Г.Лодойгийн Агваанхайдавын нийгэм-улс төрийн үзэл санааны судалгаа зэрэг орно. Дээрхи бүх судалгаануудад монголын мэргэдийн намтар, уран бүтээл, үзэл санааны талаар авч үзэхдээ судлаач бүр өөр өөрийн гэсэн эх сурвалж материал дээр судалгаа явуулсан нь нэг нь нөгөөгөө нөхөн гүйцээх, уншигч түмэнд улам бүр өргөн шинэ мэдээлэл, санаа оноо өгөх ач холбогдолтой ажил болсон юм. Энэ ажлын хүрээнд Монголын буддын нэрт сэтгэгч, зая бандид Лувсанпэрэнлэйн намтар, уран бүтээлийн тоймыг шинэ шинэ мэдээ сэлтээр баяжуулан системчлэн гаргаж, түүний шашин-гүн ухааны үзэл санааг тайлбарлан, монголын буддын соёлын хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлсэн нэгэн чухал бүтээл бол дэд доктор Д.Дэмбэрэлдоржийн диссертацийн ажил, мөн Монголын их мэргэц Завьс Дамдины намтар, уран бүтээлийн тоймыг дэлгэрэнгүй гаргаж, логик-танин мэдэхүйн үзэл санааных нь талаар философийн түүхийн анализ-судалгаа хийсэн дэд доктор С.Янжинсүрэнгийн диссертацийн ажлыг дурдахгүй өнгөрүүлж болохгүй.

МУИС-ийн Буддын судлалын ангид буддын чойрын таван ботийг тус тусад нь биеэ даасан хичээлүүд болгон үзэж судалж байгаа нь буддын дотоод

ухааны уламжлалт сургалтыг шинжлэх ухааны хүрээнд сэргээх гэсэн оролдлого мөн. Энд Учир шалтгааны ухааныг дэд доктор С.Янжинсүрэн, Абхидарма болон Билиг барамидын аймгийг миний бие, Төв үзлийг доктор Т.Булган, Тогтсон тааллын аймгийг гэвш Д.Энхтөр нар хариуцан зааж байгаа бөгөөд тус тусын чиглэлээр судалгаагаа өргөжүүлэн тэлсээр байна.

Энэ мэт буддын философи сургалт, судалгаа нь бүхэлдээ монголчуудын философи сэтгэлгээний уламжлалыг сэргээн, шинэ мэдээ баримтууд, эх сурвалж зохиолуудыг тодруулан судалгааны эргэлтэд оруулах, утга агуулга, үзэл санааг нь эдүгээчлэн тайлбарлах, улмаар буддын философийг өнөө үеийн судлаачдын оюун сэтгэлгээний нэг чухал бүрэлдхүүн хэсэг болгон хөгжүүлэхэд чиглэж байгаа болно.